

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ 63.6 ХУВЬТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ГСА-2025/06-6-ШТА-НА

Говьсүмбэр

2025 оны 05 сар

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Дарханбат Утас: 70543179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: WWW.AUDIT.MN

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 213 тоот

2025 оны 04 дүгээр сар

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна. 9

1. А.1. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй 77 хувь нь нийцсэн байна.....9
2. А.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.....9
3. А.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй нийт 12 төсөл, арга хэмжээ баталсан байна.....10
4. А.4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд 835.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.....12

Тендерийн баримт бичигт хоёрдмол утга санаа бүхий шалгуур тусгасан, захиалагч төсөвт өртгийг нэгтгэн багцын дүнгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. 14

5. Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын аргыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгосон байна.....14
6. Б.2 Тендерийн баримт бичгийн шалгуурт хоёрдмол утга санаа бүхий шаардлага тусгасан байна.....14
7. Б.3 Хуульд заасан нэмэлт гэрээ байгуулах шаардлагыг хангаагүй 2 төсөл арга хэмжээнд 17.0 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулж, тоног төхөөрөмж худалдан авах 87.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг нэгтгэн багц болгож тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.....15

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 63.6 хувьтай хэрэгжсэн байна. 16

8. В.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.....16
9. В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 63.6 хувьтай байна.17
10. В.3 Ашиглалтад хүлээн авсан 5 төсөл, арга хэмжээ нь техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээтэй нийцэхгүй байна.....18
11. В.4 Ашиглалтад хүлээн авсан 4 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаагүй нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.19



Дүгнэлт

Зөвлөмж

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГСА	Говьсүмбэр аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨАГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТ	Техникийн тодорхойлолт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХА	Харьцуулалтын арга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ШХА	Шууд худалдан авалт
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/108 дугаар тушаал Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын
зорилт:

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлт:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэр
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт
- Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2023 оны А/261 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”
- Барилга, байгууламжийн батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, байгуулсан гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын
хамарсан
хүрээ:

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд, аймгийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар зэрэг холбогдох бусад байгууллагыг хамруулан, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын
арга зүй:

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Г.Ариунцэцэг, Б.Соёлмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлүүлж, тайланг шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл
бэрхшээл:

Тус аудитыг 2025.06.15-ны өдөр дуусгах төлөвлөгөөтэй байсан, улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн Нэгтгэсэн санхүүгийн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт зэрэг 4 аудитын хугацаа давхардсан нь аудитад зарцуулах цаг хугацаа багасах, чанарт нөлөөлж болзошгүй хүндрэл бэрхшээл үүсгэсэн.

ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05 дугаар тогтоолоор Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтыг 1,543.0 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнээс шинээр хэрэгжих 1,365.0 сая төгрөгийн 14, шилжих 178.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг тус тус баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 сарын 25 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор тодотгол хийж шинээр хэрэгжих 2,157.8 сая төгрөгийн 28, шилжих 178.0 сая төгрөгийн 5, нийт 33 төсөл, арга хэмжээг 2,335.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталжээ.

(сая төгрөгөөр)

№	Хөрөнгө оруулалтын ТАХ-ний ангилал	2023 оноос дамжсан		2024 онд шинээр хэрэгжих	
		Тоо хэмжээ	төсөвт өртөг	Тоо хэмжээ	төсөвт өртөг
1	Барилга байгууламж			2	200.0
2	Их засвар, тохижилт			6	826.6
3	Тоног төхөөрөмж			14	990.3
4	Авто зам, дэд бүтэц	2	122.6		
5	Зураг төсөв	3	55.4	6	141.0
	Нийт	5	178.0	28	2,157.8

Хүснэгтээс харахад: Говьсүмбэр аймагт 2024 онд шинээр хэрэгжих 2,157.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28, өмнөх оноос дамжсан 178.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан байна.

Шинээр хэрэгжүүлэх 28 ТАХ-нээс НТШ-3, харьцуулалтын аргаар 16, шууд худалдан авалт 8, худалдан авах ажиллагаа огт зохион байгуулаагүй 1 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсноос хэрэгжээгүй 3 (Сүмбэр сумын Сансар багийн гэрэлтүүлгийг сайжруулах ажил, Хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил, Хүнс хөдөө аж ахуйн газрын конторын барилгын холболтын зураг төсөв боловсруулах) төсөл, арга хэмжээ байна.

Тайлант хугацаанд Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар ашиглалтад хүлээн авсан 1,639.2 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 21 ТАХ-нээс 475.8 сая төгрөгийн 2 засварын ажлыг урсгал зардлаар бүртгэж хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлээгүй бөгөөд 1,163.5 сая төгрөгийн 19 ТАХ-г ашиглагч байгууллагуудад бүртгүүлсэн байна.

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээний жагсаалт	11
Хүснэгт 2	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд ХАА-г зохион байгуулаагүй ТАХ-ний жагсаалт	11
Хүснэгт 3	Зориулалт бусаар зарцуулсан ТАХ-ний жагсаалт	12
Хүснэгт 4	Тухайн шатны төсөвт хамаарахгүй, өмчлөлд шилжихгүй ТАХ-ний жагсаалт	13
Хүснэгт 5	Нэмэлт гэрээ байгуулсан ТАХ-ний жагсаалт	15
Хүснэгт 6	Төсөвт өртгийг жижиглэн баталж, шууд худалдан авалт хийсэн ТАХ-ний жагсаалт	15
Хүснэгт 7	Санхүүжилтийн судалгаа	16
Хүснэгт 8	Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, гэрээний үүргээ зөрчсөн ТАХ-ний жагсаалт	17
Хүснэгт 9	Гэрээний алданги тооцоогүй төсөл арга хэмжээ	18
Хүснэгт 10	Техникийн тодорхойлолтод нийцээгүй ТАХ-ний жагсаалт	19

БҮЛЭГ А

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт хангалтгүй байгаа нь хэрэгжилт, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна.

А.1. Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ нь аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй 77 хувь нь нийцсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29^{1.2.5}¹, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3²-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ нь аймгийн бодлогын баримт бичигтэй нийцсэн байх зохицуулалттай байна.

Аймгийн ИТХ-ын 2024.09.23-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2,335.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээг баталсан. Уг жагсаалтад батлагдсан ТАХ нь аймгийн дунд богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан эсэхийг тулган баталгаажуулахад Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй 84.8, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй 81.8, Говьсүмбэр аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй 63.6 хувь нь тус тус нийцсэн байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан ТАХ нь аймгийн дунд богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Хүснэгт №1		(сая төгрөгөөр)				
№	Бодлогын баримт бичгийн нэр	Нийцсэн ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Нийцээгүй ТАХ-ны тоо	Төсөвт өртөг	Нийцсэн байдал хувиар
1	Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	28	1,565.9	5	770.0	84.8%
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2024 оны жилийн эцэс	27	1,984.4	6	351.5	81.8%
3	Говьсүмбэр аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	21	1,651.6	12	684.3	63.6%
						дундаж-77.0%

А.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.1}³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг

¹ 29^{1.2.5}.тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

² 6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

³ 29^{1.1}.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2.1.3⁴, 2.2.2⁵, 2.3.1.1⁶, 2.3.2.1⁷-т орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөхөөр тодорхой заасан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөөгүй байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

- Хөрөнгө оруулалтын жагсаалтыг боловсруулах, батлахдаа төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол зэргийг хэрхэн тооцсоныг харгалзаж үзээгүй
- Байгууллагуудаас ирүүлсэн саналыг үнэлж ач холбогдлоор нь эрэмбэлж жагсаалт гаргаагүй, хөрөнгө оруулалтын шинж чанартай эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтыг цахим системээр хийж хууль, журмын хэрэгжилтийг хангадаг боловч Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг цахимжуулаагүй.

Эдгээр нь эдийн засгийн болон нийгмийн ач холбогдол багатай, үр дүнгүй төсөл, арга хэмжээ батлагдах эрсдэлийг бий болгож байна.

Иймд Төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нь тооцож төлөвлөх тухай зөвлөмжийг аймгийн Засаг даргад, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагааг цахимжуулах саналыг Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлахаар шийдвэрлэв.

А.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй нийт 12 төсөл, арга хэмжээ баталсан байна.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁸ 29 дүгээр зүйлийн 29¹.2.1⁹, 29¹.2.2¹⁰, 29¹.2.4¹¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 3.2¹²-т заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Гэвч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг баталгаажуулаагүй 4, газар эзэмших эрхгүй 1, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 7 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнд:

Газар эзэмших эрхгүй 1 төсөл, арга хэмжээ:

1. *Шинээр баригдах Найрамдал хотхоны гадна цахилгаан хангамжийн бкв-ын ЦДКШ болон 2*30 КВА чадалтай хаалттай-335.3 сая*

⁴ 2.1.3.Төсөл, арга хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах санал боловсруулах;

⁵ 2.2.2.Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

⁶ 2.3.1.1. тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх;

⁷ 2.3.2.1.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

⁸ 4.1.24.“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

⁹ 29¹.2.1.тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

¹⁰ 29¹.2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

¹¹ 29¹.2.4.урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

¹² 3.2.Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага;

Төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулаагүй 4 төсөл, арга хэмжээ:

1. Худалдаачны гудамжны үлдэгдэл санхүүжилт-50.0 сая

“Алтай рөүд” ХХК-иар 2023 онд 214.5 сая төгрөгөөр уг ажлыг гүйцэтгүүлж, 2024.11.27-ны өдөр хүлээн авсан байна. Орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулаагүй, шалтгаан нөхцөл тодорхой бус байхад уг ажлын төсөвт өртгийг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан.

2. Халуун усны барилгын ажлын үлдэгдэл санхүүжилт-150.0 сая

“Юу Би Жи” ХХК-тай 2022.05.27-нд 350.1 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна. Орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад ажлын тоо хэмжээ зөрүүтэй байсан шалтгаанаар төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулалгүй 150.0 сая төгрөгөөр төсвийг нэмж баталсан.

3. Орон нутгийн өмчийн орон сууцуудын байрны засварын ажил-432.8 сая магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй.

4. Сүмбэр сум Сансар багт хүүхдийн тоглоомын талбай барих ажил-150.0 магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй.

Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 7 төсөл, арга хэмжээ:

Аймгийн ИТХ-ын 2024.09.23-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын жагсаалтад хөрөнгө оруулалтын шинж чанар агуулаагүй, урсгал зардлын шинжтэй нийт 365.5 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээний жагсаалт
Хүснэгт №1 (сая төгрөгөөр)

№	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСӨВ ӨРТӨГ	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА
1	Баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	75.0	2024
2	Зорилтот бүлгийн иргэдэд гэр худалдан авах ажил	150.0	2024
3	Аймгийн аюулгүйн нөөцөд өвс тэжээл худалдан авах	80.0	2024
4	Монгол гэрийн халаалт, дулаалга, агааржуулалтын багцыг худалдан авах	20.0	2024
5	Шилжиж ирсэн албан хаагчдад бэлтгэсэн гэрийн нэмэлт иж бүрдэл	11.5	2024
6	Багш нарын ажлын байрыг сайжруулахаар шаардлагатай т.төх хангах	20.0	2024
7	Шивээговь сумын 3-р цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өрөө тохижуулахад шаардлагатай эд зүйл худалдан авах	9.0	2024
НИЙТ		365.5	

(Эх сурвалж: Аудитын судалгаа)

Хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг төлөвлөн, баталж байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Иймд урсгал зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төлөвлөхгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.4. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд 835.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹³, 13.3¹⁴-т заасан төсөл, арга хэмжээг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг хориглосон. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ жагсаалт нь хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасантай нийцсэн боловч хуулийн 13.1-т заасантай нийцээгүй байна. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд ХАА-г зохион
байгуулаагүй ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №2		(сая төгрөгөөр)				
Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	ХАА зохион байгуулсан хугацаа		Гэрээний дүн	Зөрүү Хэмн	Тайлбар
		Эхлэх	Дуусах			
Сүмбэр сумын 1 болон 5 дугаар сургуулийн сурагчдын бие засах өрөөний засварын ажил	139.4	11/19	11/27	138.3	1.1	Төсвийн тодотгол
Баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	75.0	07/09	07/19	75.0	0	
Сүмбэр сумын Сансар багийн гэрэлтүүлгийг сайжруулах ажил	30.0	07/02	09/24	-	30	
Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг сайжруулах, хогийн сав суурилуулах ажил	29.2	07/02	07/17	28.8	0.4	
Худалдаачны гудамжны тохижилтын ажил	50.0	07/08	09/20	49.9	0.1	ХАА-г хуулийн хугацаанд зохион байгуулаагүй.
Халуун усны барилгын үлдэгдэл ажил	150.0	09/11	10/02	149.9	0.1	
Аймгийн өвс тэжээлийн нөөцөд өвс тэжээл худалдан авах	80.0	08/01	08/27	78.5	1.5	
Хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил	50.0	08/01	-	-	50	
Баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	75.0	07/09	07/23	75	0	
Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	156.8	09/10	10/10	154.8	2	ХАА-ны үр дүнгээр 142.7 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч захиалагч 12.1 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.
Нийт дүн	835.4			750.2	85.2	

(Эх сурвалж: АИТХ-ын тогтоолууд 2023 оны 5, 2024 оны 4, 7, 3-р тогтоол)

Хүснэгтээс харахад: 835.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1¹⁵, 13.1.2¹⁶ -т заасны дагуу зохион байгуулаагүй бөгөөд зарцуулаагүй үлдэгдлийг хэмнэлтэд тооцож төвлөрүүлээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв. Дээрх төсөл арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанаас хойш зарлаж зохион байгуулсан нь Худалдан авах ажиллагааны хуулийн сонгон шалгаруулалтын үйл явц нөлөөлөөгүй байна.

¹³ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

¹⁴ 13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

¹⁵ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

¹⁶ 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох

Мөн хуулийн 13.1.4¹⁷-т заасныг зөрчиж гэрээ байгуулснаас 138.3 сая төгрөгийн “Сүмбэр сумын 1 болон 5 дугаар сургуулийн сурагчдын бие засах өрөөний засварын ажил” төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тоног төхөөрөмж ангилалд баталсан 352.1 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 6 төсөл, арга хэмжээнээс 175.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Зориулалт бусаар зарцуулсан ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №3		(сая төгрөгөөр)			
№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Тавилга, эд хогшилд зориулалт бусаар зарцуулсан	Гэрээний дүнд эзлэх хувь
1	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж	45.5	45.5	12.2	27%
2	Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	156.8	154.8	33.2	21%
3	Баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	75.0	75.0	75.0	100%
4	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тоног төхөөрөмж худалдан авах	27.5	19.9	14.7	74%
5	Иргэний танхимд шаардлагатай тоног төхөөрөмж	50.0	37.2	22.7	61%
6	Багш нарын ажлын байрыг сайжруулахаар шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	20.0	19.8	17.3	87%
Нийт		374.8	352.1	175.1	50%

(Эх сурвалж: АИТХ-ын 2024 оны 3-р тогтоол, хөрөнгө оруулалтын ажлын техникийн тодорхойлолт, хүлээн авсан акт)

Тоног төхөөрөмж ангилалд батлагдсан төсвөөс 175.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁸, 41 дүгээр 41.2.2¹⁹, 41.2.3²⁰-т заасныг тус тус зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24²¹, 6 дугаар зүйлийн 6.6.6²²-т заасныг зөрчин тухайн шатны төсөвт хамаарахгүй, өмчлөлд шилжихгүй улсын төсвийн байгууллагуудын тоног төхөөрөмжийг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №4		(сая төгрөгөөр)			
Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Ашиглагч байгууллага	Үүнээс тухайн байгууллагад хамаарах дүн	Тухайн шатны төсөвт хамаарах эсэх	Тухайн шатны хуулийн этгээдийн өмчлөлд шилжих эсэх
Төрийн байгууллагуудад шаардлагатай т.төх худалдан авах	154.8	Татварын газар	30.0	Үгүй	Үгүй
Нийт дүн	154.8		30.0		

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

¹⁷ 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

¹⁸ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

¹⁹ 41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

²⁰ 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

²¹ 4.1.24."төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

²² 6.6.6.тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.

Хүснэгтээс харахад: Тухайн шатны төсөвт хамаарахгүй, орон нутгийн өмчлөлд шилжих 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг улсын төсвийн байгууллагуудад нийлүүлжээ.

Иймд тухайн шатны төсөвт хамаарах, хуулийн этгээдийн өмчлөлд бүрэн шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөх, Татварын газарт бүртгүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ Б

Тендерийн баримт бичигт хоёрдмол утга санаа бүхий шалгуур тусгасан, захиалагч төсөвт өртгийг нэгтгэн багцын дүнгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Б.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын аргыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн сонгосон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэх 2,157.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ-нээс НТШ-ын аргаар 904.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй-3, харьцуулалтын аргаар 1,123.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16, шууд худалдан авалтаар 109.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагаа огт зохион байгуулаагүй 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээ байна.

Үүнээс худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон шалтгаанаар хэрэгжээгүй 107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 (Сүмбэр сумын Сансар багийн гэрэлтүүлгийг сайжруулах ажил, Хэсэгчлэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил, Хүнс хөдөө аж ахуйн газрын конторын барилгын холболтын зураг төсөв боловсруулах) төсөл, арга хэмжээ байна.

Цаашид төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа удаа дараа амжилтгүй болж байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж, төлөвлөсөн хугацаанд амжилттай зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.

Худалдан авах ажиллагааны газраас төсөл, арга хэмжээний худалдан авалтын аргыг хуульд нийцүүлэн сонгож зохион байгуулсан байна. Дэлгэрэнгүйг судалгаа №2-т харуулав.

Б.2 Тендерийн баримт бичгийн шалгуурт хоёрдмол утга санаа бүхий шаардлага тусгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1²³-т заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичгийг захиалагч батлах, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1²⁴-т заасны дагуу захиалагч техникийн тодорхойлолтод холбогдох норм, стандарт, дүрэм, зааврыг захиалагч тусгах хуулийн зохицуулалттай байна.

Үнэлгээний хороо нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дараах шаардлагыг утга агуулгын хувьд оновчтой тодорхойлоогүйгээс хоёрдмол утга санаа үүссэн байна. Үүнд:

1. ТНЗ 18.1-т Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” *Багц тус бүр дээр 2021, 2022, 2023 онд гүйцэтгэсэн ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний талаар V бүлгийн МАЯГТ 3, МАЯГТ 5-ын дагуу бэлтгэж ирүүлнэ.* гэж заасан боловч “Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажил”, Иргэний танхимд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах”, “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж худалдан авах ажил”, “Зорилтот бүлгийн иргэдэд гэр худалдан авах ажил”, “Автобус худалдан авах ажил” зэрэг ажлуудын тендерийн баримт бичигт оролцогч

²³ 11.1.Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

²⁴ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

компаниудаас бэлтгэж ирүүлээгүй байхад сонгон шалгаруулсан байна. Энэ нь ижил төрлийн тендер шалгаруулалтын баримт бичигт гарсан гомдолд Сангийн яамны 2024.04.15-ны өдрийн 03/2631 тоот албан бичгээр өгсөн хариуг үндэслэсэн үнэлгээ хийжээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн шалгуурт ойлгомжгүй, хоёрдмол утга санаа бүхий мэдээлэл тусгаснаар шаардлага хангахгүй оролцогч шалгарах нөхцөл бүрдэх, худалдан авах ажиллагааны зарчим алдагдах сөрөг үр дагавартай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1²⁶, 11 дүгээр зүйлийн 11.2²⁷, 17 дугаар зүйлийн 17.2.2²⁸, 17 дугаар зүйлийн 17.4²⁹, 28 дугаар зүйлийн 28.1.3³⁰-т заасантай нийцээгүй тул Худалдан авах ажиллагааны газарт зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.3 Хуульд заасан нэмэлт гэрээ байгуулах шаардлагыг хангаагүй 2 төсөл арга хэмжээнд 17.0 сая төгрөгийн нэмэлт гэрээг байгуулж, тоног төхөөрөмж худалдан авах 87.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг нэгтгэн багц болгож тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Тайлант хугацаанд шинээр хэрэгжих 2,157.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 ТАХ-нээс 24 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 1,941.5 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Захиалагч буюу аймгийн ЗДТГ нь тендер шалгаруулалтаар шалгарсан 2 гэрээний дүнг хуульд заасан шаардлагыг зөрчиж 17.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,958.5 сая төгрөгийн гэрээг байгуулсан байна.

Нэмэлт гэрээ байгуулсан ТАХ-ний жагсаалт						
Хүснэгт №5						
(сая төгрөгөөр)						
Төсөл, арга хэмжээний нэр	ХАА-ны арга	Батлагдсан төсөвт өртөг	ХАА-ны үр дүнгээр шалгарсан дүн	Захиалагчаас байгуулсан нэмэлт гэрээний дүн	Нийт гэрээний дүн	Тайлбар
Иргэний танхимд шаардлагатай тоног төхөөрөмж	ХА	50.0	32.3	4.9	37.2	ХА-ын үед нэмэлт гэрээ байгуулахгүй
Төрийн байгууллагуудад шаардлагатай т.төх худалдан авах	НТШ	156.8	142.7	12.1	154.8	Хуульд заасан шаардлага үүсээгүй
Нийт дүн		206.8	176.0	17.0	192.0	

(Эх сурвалж: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын судалгаа)

Мөн тоног төхөөрөмж худалдан авах 87.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээг нэгтгэн 1 багц болгож тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр жижиглэн тус бүрд нь шууд худалдан авалт хийсэн байна.

²⁵ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

²⁶ 5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

²⁷ 11.2.Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

²⁸ 17.2.2.бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;

²⁹ 17.4.Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

³⁰ 28.1.3 шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах.

Төсөвт өртгийг жижиглэн баталж, шууд худалдан авалт хийсэн
ТАХ-ний жагсаалт

Хүснэгт №6

(сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний нэр	ХАА- ны арга	Батлагдсан төсөвт өртөг	ШХА хийсэн дүн
Аймгийн нэгдсэн эмнэлэгт цогцос хадгалах хөлдөөгч /хөргүүр/ худалдан авах	ШХА	20.0	18.7
Цаг агаарт зориудаар нөлөөлөх, чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	ШХА	10.0	9.9
Монгол гэрийн халаалт, дулаалга, агааржуулалтын багцыг худалдан авах	ШХА	20.0	18.5
Шилжиж ирсэн албан хаагчдад бэлтгэсэн гэрийн нэмэлт иж бүрдэл	ШХА	11.5	11.5
Шивээговь сумын 3-р цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өрөө тохижуулахад шаардлагатай эд зүйл худалдан авах	ШХА	9.0	9.0
Багш нарын ажлын байрыг сайжруулахаар шаардлагатай т.төх хангах	ШХА	20.0	19.8
Нийт дүн		90.5	87.4

(Эх сурвалж: Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын судалгаа)

Эдгээр нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1³¹, 10 дугаар зүйлийн 10.3.3³², 36 дугаар зүйлийн 36.1.3³³-т заасныг тус тус зөрчсөн тул захиалагчид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

БҮЛЭГ В

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгосон боловч хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт 63.6 хувьтай хэрэгжсэн байна.

В.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2 дугаар зүйлийн 2.3.2.4³⁴, 4.8.12³⁵-т санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгохоор заасан байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын жагсаалтад 2,335.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2,335.9 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 33 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр хугацаанд нь 1,679.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, хэрэгжиж дууссан 21 ТАХ-нээс барьцаа хөрөнгө байршуулах шаардлагатай 18 ТАХ-ний 78.6 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Мөн гэрээний хугацааг баримтлаагүй 4 ТАХ-нээс 6.5 сая төгрөгийн алданги тооцож хүү, торгуулийн орлогын дансанд төвлөрүүлсэн бол хугацаандаа хэрэгжээгүй болон дутуу хэрэгжсэн ТАХ-ний үлдэгдэл санхүүжилт 656.3 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

³¹ 5.1.Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

³² 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

³³ 36.1.3.нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авсан барааны нэмэлт нийлүүлэлт анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүргэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол;

³⁴ 2.3.2.4.төсөл, арга хэмжээний гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулах, энэ журмын холбогдох хавсралтад заасан маягтын дагуу хяналтын хуудас хөтлөх;

³⁵ 4.8.12.Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно:

Санхүүжилтийн судалгаа

Хүснэгт №7

(сая төгрөгөөр)

Төсөвт өртөг бодит	Санхүүжих дүн	Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт	Барьцаа	ОНТХО-ын дансны зарлагын дүн	Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.
2,731.9	2,335.9	1,601.0	78.6	1,679.6	656.3

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын баримт, дансны хуулга, аудитын судалгаа)

Аймгийн ИТХ-ын 2024.09.23-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар он дамжин хэрэгжих 574.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ-ний төсөвт өртгийг нийт дүнгээр батлаагүй бөгөөд зөвхөн тухайн онд санхүүжих дүн болох 178.0 сая төгрөгөөр баталсан байна. Цаашид төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нийт дүнгээр, тухайн жилд санхүүжих дүнгээс тусад нь батлах шаардлагатай байна.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 63.6 хувьтай байна.

Тайлант хугацаанд 1,639.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1,541.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-г хүлээн авсан бөгөөд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын дагуу гэрээг дүгнэсэн байна.

2024 онд нийт 2,335.9 сая төгрөгийн 33 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталснаас 1,541.0 сая төгрөгийн 21 ТАХ-г хүлээн авч хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 63.6 хувьтай хэрэгжсэн байна. Зорилтот түвшинд хүрээгүй дараах төсөл, арга хэмжээ төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Гэрээний үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй 667.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ /хавсралт №1/
- Худалдан авах ажиллагааны дүнгээр гүйцэтгэгч шалгараагүй 107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ
- Худалдан авах ажиллагааг огт зохион байгуулаагүй 20.0 сая төгрөгийн 1 ТАХ байна.

Гэрээний алданги тооцоогүй төсөл арга хэмжээ

Хүснэгт №9

(сая төгрөгөөр)

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн	Алдангийн хувь /хоног/	Гэрээний хугацаа хэтэрсэн хоног	Алдангийн дүн /гэрээний дүнгийн 10 хувь/
1	1-р багт дахин төлөвлөлт хэрэгжүүлэх байршилд ерөнхий төсөв боловсруулах зураг	Жаргалант хийц ХХК	18.4	0.05	1240	1.8
2	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	Перфектсолюшн ХХК	22.5	0.05	988	2.25
3	Сүмбэр сумын Найрамдал хотхонд шинээр баригдаж байгаа барилгуудын цахилгаан хангамжийн ажил	СОДОН ЭРЧИС ХХК	94.4	0.5	140	9.44
4	Шинээр баригдах Найрамдал хотхоны гадна цахилгаан хангамжийн бкв-ын ЦДКШ болон 2*30 КВА чадалтай хаалттай	ОСО констракшн	240.9	0.5	634	24.09
НИЙТ			376.2			37.6

(Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээ)

Төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй гэрээний хугацаа дууссан ч гүйцэтгэгч байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэрээний хугацаанаас 140-1240 хоног хэтэрсэн дээрх 4 төсөл,

арга хэмжээнд гэрээнд заасан нөхцөлийн дагуу 37.6 сая төгрөгийн алданги тооцох, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3³⁶-т заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

В.3 Ашиглалтад хүлээн авсан 5 төсөл, арга хэмжээ нь техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээтэй нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд ашиглалтад хүлээн авсан дараах төсөл, арга хэмжээнүүд нь техникийн тодорхойлолтод нийцээгүй байна. Үүнд:

Хүснэгт №10					(сая төгрөгөөр)
№	Төсөл арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Ашиглагч байгууллага	Илэрсэн нөхцөл байдал	Мөнгө н дүн
1	Төрийн байгууллагуудад шаардлагатай т.төх худалдан авах	154.8	БТСГазар	ТТ-д хүндрүүлэгчтэй байх шаардлагыг тусгасан боловч хүндрүүлэгчийг нийлүүлээгүй.	24.2
2	Сүмбэр сумын 1 болон 5 дугаар сургуулийн сурагчдын бие засах өрөөний засварын ажил	138.3	1, 5-р сургууль	ТТ-д заасан ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан боловч төсөвт өртгийн зөрүүг тооцож баталгаажуулаагүй.	-
3	Багш нарын ажлын байрыг сайжруулахаар шаардлагатай т.төх хангах	19.8	2-р сургууль	5 нэр төрлийн 11 ширхэг номыг ТТ-д заасны дагуу нийлүүлээгүй.	0.2
			2-р сургууль	ТТ-д акустик самбар нийлүүлэхээр тусгасан боловч самбарын бэлдэцийг нийлүүлсэн.	1.6
4	Халуун усны барилга	149.9	Менежментин гэрээгээр	Халуун усны өрөөнүүдийн шалны налууг стандарт бус хийсэн. Агшин зуур халаагч нь шатсан. Ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг баталгаажуулаагүй. Ашиглалтад хүлээн авах комиссын үүрэг даалгаврыг биелүүлээгүй.	-
Нийт		472.6			26.0

